



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/654

Есөнбулаг

Орон тооны бус зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Гишүүдэд:

Засаг даргын Тамгын газрын дарга
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга
Цагдаагийн газрын дарга
Орон нутгийн өмчийн газрын дарга
Онцгой байдлын газрын дарга
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хорихоос
өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа
хариуцсан ахлах
шийдвэр гүйцэтгэгч Байгаль, орчны газрын
дарга

Нарийн бичгийн дарга:

Орон нутгийн өмчийн газрын Хууль,
хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит
хариуцсан мэргэжилтэн

2. Зөвлөлийн гишүүдийг комиссуудад дор дурдсанаар хуваарилсугай.

Үнэлгээний комисс:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Орон нутгийн өмчийн газрын Хууль,
хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит
хариуцсан мэргэжилтэн

Устгалын комисс:

Цагдаагийн газрын дарга
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга
Онцгой байдлын газрын дарга

Худалдан борлуулах комисс:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Орон нутгийн өмчийн газрын дарга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хорихоос
еер төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан
ахлах шийдвэр гүйцэтгэгч

3.Тогтоолын хэрэгжилтийг ханган, үр дүнг танилцуулж ажиллахыг Орон тооны бус
зөвлөлд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ